НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2023.02.10 № 03/867

танай ______________-ны №______________-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 488, "Журамд өөрчлөлт оруулах тухай" 491 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дарга, захирал нарын албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоосон Нийслэлийн Засаг даргын 2023 оны Б/12 дугаар захирамжийг хүргүүлж байна.

Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ И.БААТАРХҮҮ

C:\2023 он\ТГ-А5.docx

1110200931

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 24 өдөр Дугаар Б/12 Улаанбаатар хот

Албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдэл шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар, 2019 оны 276 дугаар, 2021 оны 360 дугаар, 2022 оны 107, 487, 488 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын Удирдлагын багийн үндсэн цалин, нэмэгдлийг 1 дүгээр, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн дарга нарын үндсэн цалин, нэмэгдлийг 2 дугаар, нийслэлийн орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн зарим газрын дарга нарын үндсэн цалин, нэмэгдлийг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Шинэчилсэн цалин, нэмэгдлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцож олгохыг холбогдох байгууллагуудын Нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлуудын хөдөлмөрийн хөлсийг шинэчлэн тогтоох тухай” Нийслэлийн Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/413 дугаар захирамж, “Албан тушаалын зэрэглэл, үндсэн цалин, нэмэгдэл шинэчлэн тогтоох тухай” Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Б/96 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

1110200602

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
01 дүгээр сарын 24-ний өдрийн
б/12 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРЫН
АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ, ЦАЛИН, НЭМЭГДЭЛ

| № | Албан тушаалын нэр | Овог нэр | Албан тушаалын ангилал, зэрэглэл | Үндсэн цалин | Нэмэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн алба хаасан хугацаа | Бусад |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 17 | “Улаанбаатар лифт” ОНӨТҮГ-ын дарга | Д.Ган-Эрдэнэ | | 1,300,000 | | |